

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2014 оны 11 дүгээр сарын 26-нд болов.

Тус хурлаар “Монголбанкны эрсдэлийн удирдлагын байдал, авч хэрэгжүүлж буй ажлын үр дүнтэй танилцсан зөвлөлийн гишүүн Я.Эрхэмбаярын сонсголыг хэлэлцэж Олон Улсын Төлбөр Тооцооны Банкнаас гаргасан зөвлөмжийн дагуу зохистой засаглал, дотоод аудит, эрсдэлийн удирдлага, нийцлийн чиг үүргийг багтаасан Монголбанкны дотоод хяналтын чиг үүргийг бүрдүүлж ажиллах, эрсдэлийн удирдлагын албаны үйл ажиллагааны хамрах хүрээг өргөтгөх боломжийг судлан холбогдох арга хэмжээ авахыг; “Мөнгөн тэмдэгтийн хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсныг солих, устгах ажлыг зохион байгуулж буй ажлын талаар” Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын захирал П.Сүхбаатарын сонсголыг хэлэлцээд мөнгөн тэмдэгтийг захиалж хэвлүүлэхээс авахуулаад хуучин муудсныг гүйлгээнээс татах, устгах хүртэлх үйл ажиллагааг эрсдэлд суурилсан зарчмаар зохион байгуулах тогтолцоонд шилжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх, мөнгөн тэмдэгтийг зориулалтын дагуу гамтай хэрэглэх соёлд иргэдийг сургах чиглэлээр сурталчилгааны ажил явуулахыг; Завхан аймаг дахь Монголбанкны салбарын ажилтай танилцсан тухай Хяналтын зөвлөлийн гишүүн Х.Ганбаатарын мэдээллийг сонсоод төрийн хяналтад байх объектийн жагсаалтад Монголбанкны салбарыг хамруулах арга хэмжээ авч ажиллахыг тус тус Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөв.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ